

## ЭРХЭМ ХҮНДЭТ СУРАГЧИД АА!

Энэхүү судалгаагаар суралцагчийн цогц чадамжийг хэмжиж, боловсролын чанарт нөлөөлж буй хүчин зүйлийг тогтоох, боловсролын бодлогын хэрэгжилтийг үнэлэхэд мэдээлэл цуглуулах зорилготой тул даалгавар бүрийг анхааралтай гүйцэтгэж, өөрийн мэдлэг, чадвараа бодитоор үнэлүүлэн, улс, эх орныхоо боловсролын хөгжилд хувь нэмрийг оруулаарай.

Тус судалгааны дүнг боловсролын албан ёсны баримт бичигт тэмдэглэхгүй, судалгааны зориулалтаар ашиглаж, хувь хүн болон даалгаврын гүйцэтгэлийн тухай мэдээллийн нууцыг чандлан хадгална.

Боловсролын чанарын үнэлгээнд оролцож буй танд  
Боловсрол Шинжлэх Ухааны Яам, Боловсролын үнэлгээний төвийн  
ах, эгч нар нь талархал илэрхийлж сурлагын өндөр амжилт хүсье!



## ЕРӨНХИЙ ЗААВАР

📖 Үнэлгээний дэвтэр үндсэн гурван хэсэгтэй бөгөөд хэсэг бүр зогс тэмдгээр хуваагдана. Нэгдүгээр хэсгийн даалгаврыг 40 минутын хугацаанд хийж гүйцэтгээд 10 минут амарч завсарлана. Хоёрдугаар хэсгийг 30 минутын хугацаанд хийж гүйцэтгээд шалгагч багшийн заавраар багт хуваагдан, гуравдугаар хэсгийн даалгаврыг багаараа хамтарч 15 минут ажиллана.

📖 Хэсэг тус бүрийн өмнөх санамжийг анхааралтай уншиж даалгаврыг хийж гүйцэтгээрэй.

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

### Санамж:

- ✓ Даалгавар бүрийн зааврыг анхааралтай уншиж гүйцэтгээрэй. Даалгаврыг гүйцэтгэхэд шаардлагатай бүх мэдээллийг зураг, график, үгэн мэдээлэл хэлбэрээр өгсөн байгааг ашиглаарай.
- ✓ Нэгдүгээр хэсгийг зогс тэмдэг хүртэл 40 минутад хийж гүйцэтгээд завсарлаарай.

### ► Асуудал шийдвэрлэх чадвар

#### Хаягдал цаасыг дахин боловсруулах ямар ашиг тустай вэ?

Говь-Алтай, Ховд аймгийн есөн сумын эко клубийн сурагчид нэг сарын хугацаанд сургуулийнхаа ойр орчмоос 627 кг хог түүжээ. Тэд түүсэн хог хаягдлаа ангилж үзэхэд дийлэнх хувийг нь цаас эзэлж байв.



Бид яагаад цаасаа ХАЯХГҮЙ хэмнэх ёстой вэ?

Хэрхэн хэмнэж болох вэ?

Цаасыг юугаар хийдэг вэ?



Нээрээ л сургууль, анги танхимд цаас их хаядаг шүү.

**Хүүд дээрх асуултуудад хариулахын тулд тооцоолол хийж, найзууддаа уриалга бичихэд туслаарай.**

#### 1.1 Жилд хэр их цаас хаягддаг юм бол?



Хүү улсын хэмжээнд хаягддаг нийт хог хаягдлын тухай мэдээлэл хайж олов.

2018 онд 2 435 800 т,  
2019 онд 2 612 600 т  
хог хаягдсан байна.





- е) Зураглалд тохирсон бодлого зохиож бичээрэй.  
 Зохиосон бодлогоо бодоорой.



**1.2) Дахин боловсруулсан цаасны ач холбогдлыг тооцоолж харуулъя.**

**1 т цаасыг дахин боловсруулахад 17 мод хамгаалдаг байна.**



17 мод 1 тонн цаас

- а) 205 100 т дахин боловсруулсан цаас хэрэглэхэд.....мод хамгаална.







Нэгдүгээр хэсэг дууслаа.  
10 минут завсарлаарай.

## ХОЁРДУГААР ХЭСЭГ

### Санамж:

- ✓ Эхийг уншиж ойлгоод, дасгал даалгавруудыг зааврын дагуу гүйцэтгээрэй.
- ✓ Хоёрдугаар хэсгийг зогс тэмдэг хүртэл 30 минутад хийж гүйцэтгээд завсарлаарай.

### » Уншиж ойлгох чадвар

#### Нээлттэй үдэш

Ноён Равдан тайзны арын жижигхэн зайд нааш цааш алхаж байв. Тэр хөмсгөө зангидчихаад, духан дээрх хөлсөө арчина. Тэрээр харанхуйлж буй тэнгэрийг ажиглаад, “Дараагийн хоёр цагт бороо битгий ороосой” хэмээн бувтнан алхаж байхдаа үүнийг хэд хэдэн удаа давтаж байлаа. Нил ягаан өнгийн нөмрөг нөмөрч, алтан титэм гартаа барьсан Тодоо, бүсэндээ модон сэлэм зүүсэн Дамдинг тохойгоороо нудрав. “Тэр юу болоод байна?” гэж Дамдингаас асуув.

- Тэр цаг орчим нааш цааш алхалж, өөртэйгөө ярилаа. Дамдин хариуд нь:

- “Би мэдэхгүй байна аа. Намайг ирэхэд тэр ийм л байсан. Гэхдээ тэр удахгүй болино оо. Цаг бараг боллоо.”

Яг тэр үед ноён Равдан гүнзгий амьсгаа аваад, хөшгийг хажуу тийш нь түлхэж, үзэгчдийн зүг алхав. “Ноёд хатагтай нар аа! Энэхүү үзэсгэлэнт задгай театрт тавтай морилно уу! Өнөө орой та бүхнийг **“Хаан буцаж ирсэн нь”** тоглолтын анхны үзүүлбэрт хүрэлцэн ирсэнд бид маш их баяртай байна.”

Ноён Равдан мэхийн ёслоод, хөшигний араар далд ортлоо ухарч алхав. Үзэгчдээс цөөн хэдэн хүн эелдгээр алга ташив.

**“Та нар сонсов уу?” гэж ноён Равдан тайзан дээр гарахаар хүлээж буй жүжигчдээс асуув. “Гайхалтай үзэгчид! Маш их догдолжээ! Тэд бидний тоглолтыг үзэхийг тэсэн ядан хүлээж байна!” гэхэд Дамдин, Тодоо хоёр гайхсан харц солилцов. “Одоо тэдний амьдралдаа үзсэн хамгийн сайхан үзүүлбэрийг үзүүлээд өг!” гэж хэлээд тайзны хажуу руу яаран очиж, хөшгөө нээлээ.**

\* \* \*

“За хүмүүс ээ! Сүүлчийн үзэгдэл шүү! Хаан ширээнд залах ёслол” гэж зургийн дарга хэллээ. “Дамдин аа! Энэ удаад титмээ аваарай.” Дамдин эргэж хараад зургийн даргаас титмээ авав. “Уучлаарай” гэж тэр тайзан дээр гарангаа шивнэлээ. Тодоо толгой дээрээ титэм барин босов. Түүний ард тайзан дээр буй жүжигчид “Хаантны өлмий бат оршиг!” гэж хашхиралдав. Алсаас аянга цахилгаан дэлдэж эхэллээ. Үзэгчдээс хэдэн хүн тэнгэр өөд хараад, дараа нь сандарсан байдалтай эргэн тойрноо ажиглацгаалаа. Ноён Равдан хөшигний ард, тайзны ирмэг рүү зөөлхөн дөхөж очив. Тэрээр “Хаан эргэж ирснийг тунхаглан алсад их буугаар буудаж байна!” гэж хашхирав. Дамдин инээгээд, дараа нь өөрийгөө хурдан болиуллаа. Ноён Равдан Дамдин руу ширтээд, дараа нь тэр үзэгчдийг харж, амьсгаагаа дарав. Тайзнаа эцсийн үгээ хэлж буй хаан шиг Тодоог үзэгчид ширтэж, сонсож байв. Тэрээр үгээ хэлж дуусахад, хөшиг хаагдлаа. Үзэгчид урам зоригтойгоор алга ташицгаав. Тайзны ард ноён Равдан хэн ч байхгүй байхад бөхийж ёслоод, сэтгэл нь тайвширсан байдалтай гүнзгий амьсгаа авлаа.

**2.1) Яагаад ноён Равдан өгүүллийн эхэнд сандарч байсан бэ?**

- A. Тэрээр цаг агаарын тааламжгүй байдал нь тоглолтыг сүйтгэх вий гэж санаа зовж байсан.
- B. Тэрээр үзэгчдэд жүжиг таалагдахгүй байх вий гэж санаа зовж байсан.
- C. Тэрээр жүжигчид өөрсдийн хэлэх үгээ мартчих вий гэж санаа зовж байсан.
- D. Тэрээр жүжиг нь муу үнэлгээ авах вий гэж санаа зовж байсан.

**2.2) Тодруулсан цогцолборт Тодоо, Дамдин нар яагаад гайхсан харц солилцсон бэ?**

.....

.....

.....

.....

.....

**2.3) “Хаан буцаж ирсэн нь” жүжгийн гол дүрд хэн тоглосон бэ? Гол дүр гэдгийг нотлох өгүүлбэрийг эхээс олж бичээрэй.**

.....

.....

.....

.....

.....

**2.4) Ноён Равдан яагаад жүжгийн сүүлчийн үзэгдлийн үеэр үзэгчдийн адил аянга сонссоныхоо дараа хашхирсан бэ?**

.....

.....

.....

.....

.....

**2.5) Жүжгийн төгсгөлд үзэгчид жүжгийг хэрхэн хүлээн авсан бэ?**

- A. Үзэгчид бороонд норохгүйн тулд хурдан явсан.
- B. Үзэгчид жүжиг их таалагдсан гэдгийг харуулсан.
- C. Үзэгчид жүжигт тоглосон жүжигчидтэй уулзахыг хүссэн.
- D. Хөшиг хаагдахад үзэгчид чимээгүй хэвээр байсан.



**2.6** Хүснэгтийг нөхөж гүйцээгээрэй.

Эхийн хэсэг	Цаг агаарын байдал	Равдангийн сэтгэл зүйн байдал	Эхээс жишээ татан бичээрэй.
Эхлэл	.....	түгшүүртэй	..... ..... .....
Төгсгөл	аянга дэлдсэн	..... ..... .....	..... ..... .....



Хоёрдугаар хэсэг дууслаа.  
Хянагч багшийн заавраар багийн зохион  
байгуулалтад орж ажиллаарай.

## ГУРАВДУГААР ХЭСЭГ

### Санамж:

- ✓ Дараах даалгаврыг ажиллахдаа хянагч багшийн зааврын дагуу багийн зохион байгуулалтад орж 3.1-р даалгаврыг багаараа ажиллахыг анхаараарай.
- ✓ 3.2, 3.3-р даалгавраар өөрийгөө тодорхойлоорой.

### ► Хамтарч асуудал шийдвэрлэх чадвар

#### Номын баяр

Сургуулийн “Номын баяр” сарын аяны хүрээнд Уран зохиол, Шинжлэх ухаан, Танин мэдэхүйн гэсэн номын булангууд бий болгохыг АУБ-аас үүрэг болгожээ. Танай багийн 5 гишүүнд “Танин мэдэхүйн ном”-ын булан үүсгэх даалгавар авсан. Багийн гишүүд эцэг, эхдээ хандан дэмжлэг хүсэхэд дараах байдлаар туслахаа илэрхийлсэн. Үүнд:

1. Би та нарт номоо тавих тавиурыг хийж өгье.
2. Би бэлэн болсон номуудыг коджуулаад, номын карт гаргаж өгье.
3. Танин мэдэхүйн сэдэвтэй ном худалдаалдаг дэлгүүр мэднэ, та нар тэндээс ном авч болно.
4. Би бэлэн болсон номуудыг хавтаслаад өгч чадна.
5. Би өөр аймагт ажиллаж байгаа тул оролцох боломжгүй байна.

**Танай баг “Танин мэдэхүйн ном”-ын буландаа номтой болох талаар хамтран ярилцаж нэг шийдвэрт хүрнэ үү. 10 минут ярилцаарай.**

Багийн дугаарыг  энд бичнэ үү.

**3.1) Багаараа ярилцаж гаргасан шийдвэрээ энд бичнэ үү.**

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

3.2 Чиний хувьд багаараа ярилцан гаргасан дээрх шийдвэртэй санал нийлж байгаа юу? ✓ тэмдэглээрэй.

- санал нийлж байна
- санал нийлэхгүй байна

Яагаад? Хариултаа тайлбарлана уу.

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

3.3 Багаараа ажиллахад чи ямар үүрэгтэй байсан бэ? Сонгож дугуйлаарай.

- А. Би сайн санаа гаргасан хэдий ч дэмжигдээгүй.
- Б. Би санал хэлээгүй ч сайн сонсогч байж чадсан.
- В. Би гарсан саналыг сайжруулсан.
- Г. Би энэ санааг гаргаж, бусад хүүхдүүд намайг дагасан.

**ЗАСАЛТЫН ХҮСНЭГТ**

*Засагч багшид зориулав.*

Асуудал шийдвэрлэх чадвар

1.1a	
1.1b	
1.1c	
1.1d	
1.1e	
1.2a	
1.2b	
1.2c	

Уншиж ойлгох чадвар

2.1	
2.2	
2.3	
2.4	
2.5	
2.6	

Хамтарч асуудал шийдвэрлэх чадвар

3.1	
3.2	
3.3	